

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**БУЛГАН СУМЫН ХҮҮХДИЙН 1-Р ЦЭЦЭРЛЭГИЙН 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Аудитын код: ХОА-2021/145/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>Ховд хот 2021 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: BoldbaatarKh@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг: Tsetsegsurena@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Эрдэнэцэцэг Утас: 70432545 цахим хаяг: ErdenetsetsegD@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

### Товчилсон үгийн жагсаалт

<i>АДБОУС</i>	<i>Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт</i>
<i>АОУС</i>	<i>Аудитын Олон Улсын Стандарт</i>
<i>УСНББОУС</i>	<i>Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт</i>
<i>ТТЗ</i>	<i>Төсвийн төвлөрүүлэн захирагч</i>
<i>ТШЗ</i>	<i>Төсвийн шууд захирагч</i>
<i>БСУГ</i>	<i>Боловсрол, Соёл, урлагийн газар</i>
<i>НДШ</i>	<i>Нийгмийн даатгалын шимтгэл</i>
<i>ХАОАТ</i>	<i>Хүн амын орлогын албан татвар</i>
<i>БуЗДТГ</i>	<i>Булган сумын Засаг даргын тамгын газар</i>
<i>СТСХ</i>	<i>Санхүү, Төрийн сангийн хэлтэс</i>
<i>БШУЯ</i>	<i>Боловсрол шинжлэх ухааны яам</i>

## Агуулга

1.Төрийн аудитын байгууллагын санал, дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	9
3. Аудитын тайлан .....	10
3.1. Ерөнхий зүйл .....	10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт.....	11
3.4. Материаллаг байдал .....	11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	11
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	12
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	13
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14
3.9. Аудитын илрүүлэлт.....	14
Залруулсан алдаа .....	14
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....	
Аудитын зөвлөмж .....	14
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	14
4. Менежментийн захидал .....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	16

## 1.ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН САНАЛ, ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

2021.06.25 № 4/101  
таний \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

БУЛГАН СУМЫН 1-Р ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧ О.ТҮМЭНЖАРГАЛ ТАНАА

### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын 1-р цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган сумын 1-р цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан, Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. *Бусад мэдээлэл нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайлан, сургалтын үнэлгээ, сургалтын орчин, сургуулийн өмнөх боловсрол олгох, сургалтын арга зүйн мэдээллийн бодит байдал зэрэг санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.*

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

001020539

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>86,483,092.62</u>	<u>85,815,827.62</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	85,743,479.62	85,815,827.62
351	Түүхий эд материал	00.00	624,000.00
35130	Эм боох материал	00.00	624,000.00
354	Хангамжийн материал	85,743,479.62	85,191,827.62
35410	Бичиг хэргийн материал	3,121,650.00	2,658,480.00
35420	Аж ахуйн материал	67,760,551.62	69,613,749.62
35440	Түлш, шатах тослох материал	3,973,000.00	4,702,500.00
35450	Барилгын засварын материал	286,000.00	425,000.00
35460	Хүнсний материал	10,602,278.00	7,792,098.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>794,607,114.89</u>	<u>803,022,200.33</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	794,607,114.89	803,022,200.33
392	Биет хөрөнгө	784,007,114.89	792,422,200.33
39201	Барилга, байгууламж, орон сууц	768,439,250.00	768,439,250.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-12,640,654.20	-25,447,975.08
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	51,782,903.00	66,650,999.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-45,892,628.80	-47,482,982.35
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	105,997,666.64	117,847,666.64
39208	Хуримтлагдсан элэгдэл	-87,018,221.75	-92,953,557.88
39214	Бусад үндсэн хөрөнгө	00.00	2,000,000.00
39217	Ном	3,338,800.00	3,368,800.00
393	Биет бус хөрөнгө	10,600,000.00	10,600,000.00
39301	Програм хангамж	275,000.00	275,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-275,000.00	-275,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	10,600,000.00	10,600,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>881,090,207.51</u>	<u>888,838,027.95</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	20,500.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	20,500.00
413	Өглөг	00.00	20,500.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	20,500.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>881,090,207.51</u>	<u>888,817,527.95</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	881,090,207.51	888,817,527.95
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	205,511,552.00	205,511,552.00
51101	Өмч: - төрийн	205,511,552.00	205,511,552.00
512	Хуримтлагдсан үр дүн	33,155,373.59	40,882,694.03
51210	Өмнөх үеийн үр дүн	33,155,373.59	33,155,373.59
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	7,727,320.44
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	642,423,281.92	642,423,281.92

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	881,090,207.51	888,838,027.95
---	---	----------------	----------------

## 2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	715,335,445.00	779,859,862.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,808,915.00	28,907,200.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,808,915.00	28,907,200.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,808,915.00	28,907,200.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	4,808,915.00	28,907,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	50,053,530.00	49,675,362.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	660,473,000.00	701,277,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,000,000.00	4,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,000,000.00	4,500,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	30,304,300.00	30,257,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	30,304,300.00	30,257,700.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	9,749,230.00	14,917,662.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	9,749,230.00	14,917,662.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	719,806,432.50	772,132,541.56
21	УРСГАЛ ЗАРДАЛ	719,806,432.50	772,132,541.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	710,357,202.50	711,381,629.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	484,876,513.00	532,075,224.78
210101	Үндсэн цалин	484,876,513.00	532,075,224.78
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	62,346,991.00	69,744,683.13
210201	Тэтгэврийн даатгал	62,346,991.00	69,744,683.13
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,174,036.00	28,866,357.00
210301	Гэрэл, цахилгаан	6,129,886.00	4,049,357.00
210302	Түлш, халаалт	37,044,150.00	24,817,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,861,671.00	7,971,805.00
210401	Бичиг хэрэг	2,537,200.00	3,068,970.00
210402	Тээвэр, шатахуун	7,974,471.00	3,921,605.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,350,000.00	981,230.00
2105	Нормативт зардал	83,856,724.00	43,059,280.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	2,851,000.00
210502	Хоол, хүнс	83,856,724.00	40,208,280.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	620,750.00	5,951,299.00
210604	Урсгал засвар	620,750.00	5,951,299.00
2107	Томилолт, зочны зардал	150,000.00	550,000.00
210702	Дотоод албан томилолт	150,000.00	550,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	200,000.00	200,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000.00	200,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,270,517.50	22,962,980.56
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,143,600.00	2,629,970.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	21,126,917.50	20,333,010.56

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,449,230.00	60,750,912.09
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,449,230.00	14,917,662.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	9,449,230.00	14,917,662.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	45,833,250.09
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	45,833,250.09
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-4,470,987.50	7,727,320.44
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-4,470,987.50	7,727,320.44

### 2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	167,454,800.00	753,952,662.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	3,000,000.00
120009	Бусад орлого	00.00	3,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	167,454,800.00	750,952,662.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	167,454,800.00	701,277,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	4,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	4,500,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	30,257,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	30,257,700.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	00.00	14,917,662.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	00.00	14,917,662.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	147,462,429.00	753,952,662.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	147,462,429.00	753,952,662.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	147,462,429.00	690,201,749.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	118,853,689.00	531,335,611.91
210101	Үндсэн цалин	118,853,689.00	494,329,437.91
210102	Нэмэгдэл	00.00	24,072,414.00
210104	Урамшуулал	00.00	12,933,760.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	530,000.00	69,744,683.00
210201	Тэтгэврийн даатгал	530,000.00	69,744,683.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,650,000.00	29,603,257.00
210301	Гэрэл, цахилгаан	650,000.00	4,049,357.00
210302	Түлш, халаалт	8,000,000.00	25,553,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	444,600.00	4,702,835.00
210402	Тээвэр, шатахуун	444,600.00	3,721,605.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	00.00	981,230.00
2105	Нормативт зардал	17,589,540.00	41,892,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	3,512,500.00
210502	Хоол, хүнс	17,485,540.00	37,397,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	104,000.00	982,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	5,549,030.00
210604	Урсгал засвар	00.00	5,549,030.00
2107	Томиллот, зочны зардал	00.00	550,000.00
210702	Дотоод албан томиллот	00.00	550,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	200,000.00	3,200,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000.00	200,000.00
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	19,992,371.00	3,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,194,600.00	6,623,833.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,194,600.00	6,623,833.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	00.00	60,750,912.09
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	14,917,662.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	00.00	14,917,662.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	45,833,250.09
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	45,833,250.09
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

## 2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	205,511,552.00	642,423,281.92	33,155,373.59	881,090,207.51
D01	2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	205,511,552.00	642,423,281.92	33,155,373.59	881,090,207.51
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	205,511,552.00	642,423,281.92	33,155,373.59	881,090,207.51
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	7,727,320.44	7,727,320.44
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	205,511,552.00	642,423,281.92	40,882,694.03	888,817,527.95

## 2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	731,485,000.00	685,701,749.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	731,485,000.00	685,701,749.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	731,485,000.00	685,701,749.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	543,335,800.00	531,335,611.91
210101	Үндсэн цалин	356,012,500.00	494,329,437.91
210102	Нэмэгдэл	147,417,500.00	24,072,414.00
210104	Урамшуулал	39,905,800.00	12,933,760.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	73,350,300.00	69,744,683.00
210201	Тэтгэврийн даатгал	51,616,800.00	69,744,683.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,433,400.00	00.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,346,700.00	00.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,086,700.00	00.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,866,700.00	00.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,032,900.00	29,603,257.00

210301	Гэрэл, цахилгаан	4,212,500.00	4,049,357.00
210302	Түлш, халаалт	26,420,400.00	25,553,900.00
210303	Цэвэр, бохир ус	400,000.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,980,100.00	4,702,835.00
210401	Бичиг хэрэг	253,900.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	1,909,700.00	3,721,605.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	208,900.00	981,230.00
210404	Ном, хэвлэл	145,200.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	462,400.00	00.00
2105	Нормативт зардал	72,473,000.00	41,892,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,405,000.00	3,512,500.00
210502	Хоол, хүнс	69,080,400.00	37,397,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,987,600.00	982,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	281,600.00	1,049,030.00
210604	Урсгал засвар	281,600.00	1,049,030.00
2107	Томилолт, зочны зардал	263,000.00	550,000.00
210702	Дотоод албан томилолт	263,000.00	550,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	343,600.00	200,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	343,600.00	200,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7424700.00	6623833.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,455,900.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,968,800.00	6,623,833.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>731,535,000.00</b>	<b>685,701,749.90</b>
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>701,277,300.00</b>	<b>655,444,049.90</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	701,277,300.00	655,444,049.90
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>30,257,700.00</b>	<b>30,257,700.00</b>
132001	Орон нутгийн төсвөөс	30,257,700.00	30,257,700.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>53.00</b>	<b>53.00</b>
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	30.00	30.00
620003	Үйлчлэх ажилтан	22.00	22.00

## 2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>4,500,000</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>4,500,000</b>
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,500,000</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,000,000
210602	Тавилга	2,500,000
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>4,500,000</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>4,500,000</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,500,000

### 3.АУДИТЫН ТАЙЛАН

#### 3.1. Ерөнхий зүйл

Булган сумын Хүүхдийн 1-р цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг эрхлэгч О.Түмэнжаргал танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч байгууллагын төсвийн хөрөнгийн зарцуулалт, шилэн данс, үндсэн хөрөнгийн талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дүгээр сарын 20-ноос 2021 оны 02 дугаар сарын 23-ны хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Эрдэнэцэцэг хариуцаж хэрэгжүүлэв.

#### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Хүүхдийн сурах үйлийг дэмжиж, хоцрогдолгүй сургахад бүх талын оролцоо, хамтын ажиллагааг өргөжүүлж, тэдний хөгжил төлөвшилд анхаарч, хамран сургах тойргийн 2-5 насны хүүхдүүдэд үндсэн болон хувилбарт хэлбэрээр сургалт явуулж сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх сургалтын амжилт чанарыг сайжруулах, багшийн мэргэжлээрээ тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлэх зорилго дэвшүүлэн ажиллажээ. Байгууллагын үйл ажиллагааны чиглэл нь:

- ✓ Эх хэлний чадварыг хөгжүүлэх
- ✓ Боловсролын үйлчилгээнд хүн бүр оролцогч байх чадамжийг дээшлүүлэх
- ✓ Суралцах чадвар, сургалтын чанарт ахиц гаргах
- ✓ Хүүхдэд ээлтэй эрүүл орчин бүрдүүлэх
- ✓ Сумын 2-5 насны бүх хүүхдийг боловсролын үйлчилгээнд тэгш хамруулан сургах ажлыг үр дүнтэй зохион байгуулан, сургуулийн өмнөх боловсролд 5-н настай хүүхдийг бүрэн хамруулж, цэцэрлэгийн хамран сургалтыг 0,3 хувиар ахиулах
- ✓ Үндсэн болон хувилбарт, явуулын чиглэлээр үйлчилгээг хүргэж хамтарч ажиллах
- ✓ Цэцэрлэгийн үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог өргөжүүлж, эцэг эхчүүдийн хамтын ажиллагааг сайжруулах, хүүхэд хамгааллын хөтөлбөрийг хэрэгжүүлж нийгмийн эгэх хариуцлагыг нэвтрүүлж сайжруулах
- ✓ Монгол улсын засгийн газраас баталж гаргасан тогтоол шийдвэр, аймаг, суманд хэрэгжиж байгаа дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, үйл ажиллагааг сурталчлах, үр дүнг нээлттэй болгох

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”

- Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Булган сумын Хүүхдийн 1-р цэцэрлэгийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг БШУЯ-наас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор БСУГ-ын дотоод хяналт, Санхүү, дотоод аудитын албанаас 2020 онд тус байгууллагад санхүүгийн хяналт хэрэгжүүлээгүй ч сумын Төрийн сангаас өдөр тутмын санхүүгийн гүйлгээнд дотоод хяналт хэрэгжүүлсэн байна.

Байгууллагын үйл ажиллагаа, санхүүд хэрэгжүүлсэн дотоод хяналтын тайлан мэдээ байхгүй байна.

Булган сумын Хүүхдийн 1-р цэцэрлэгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинд “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинд 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зарлагын 726990.1 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 7269.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Харин гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинд 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зарлагын 772132.5 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 7721.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Булган сумын Хүүхдийн 1-р цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 7747.8 мянган төгрөгөөр буюу 7,2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
АВЛАГА	739.6	0.0	-739.6
БАРАА МАТЕРИАЛ	85,743.5	85,815.8	72.3
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	794,607.1	803,022.2	8,415.1
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>881,090.2</b>	<b>888,838.0</b>	<b>7,747.8</b>
БОГИНО ХУГАЦААТ ӨР	0.0	20.5	20.5
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН	881,090.2	888,817.5	7,727.3
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР</b>	<b>881,090.2</b>	<b>888,838.0</b>	<b>7,747.8</b>

Авлага дансны үлдэгдэл оны эцэст 0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Тайлант онд үүссэн авлагыг бүрэн барагдуулж ажилласан байна. Хүн амын орлогын албан татвар дутуу шилжүүлээд авлагаар тусгаагүй байна. Аж ахуйн нэгж байгууллагуудтай тооцоо нийлж үлдэгдлийг барагдуулсан байна.

Тайлант онд хувь хүн, аж ахуйн нэгжтэй холбоотой тооцоо хийсэн боловч тооцооны үлдэгдлийн актаар баталгаажуулж насжилт өндөртэй авлага бууруулж ажилласан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 85815.8 мянган төгрөг болж 72.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд хүүхдийн хоолны мах нөөцөлж бараа материалд үлдэгдэлтэй харагдаж байгаа нь нөлөөлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 794607.1 мянган төгрөг, оны эцэст 803022.2 мянган төгрөг болж 8415.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгийн данс нь тайлант онд төсвийн хөрөнгөөр хөрөнгө худалдаж аваагүй БСУГ-аас үнэ төлбөргүй хөрөнгөөр 8415.1 мянган төгрөгийн тоног төхөөрөмж орлого авч хөрөнгө акталж зарлагдаагүй байна.

Өр төлбөр оны эхэнд үлдэгдэл байхгүй тайлант онд 1208492.6 мянган төгрөгийн өр үүсэж бүрэн барагдуулсан бөгөөд тайлант оны эцэст 20.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл оны эцэст 888817.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Оны эхнээс 7727.3 мянган төгрөгийн тайлант үеийн үр дүнгээр өссөн байна.

Булган сумын Хүүхдийн 1-р цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 64524.4 мянган төгрөгөөр буюу 12.1 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 64524.4 мянган төгрөгийн орлого үнэ төлбөргүй хөрөнгийн орлого 24100.0 мянган төгрөгөөр, төсвийн санхүүжилтийн орлого 40424.4 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 52326.1 мянган төгрөгөөр буюу 12.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 52326.1 мянган төгрөгийн зардал нь цалингийн зардал 28132.1 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү бодлогын өөрчлөлтөөр бүртгэлийн бичилт хийгдээгүй байна.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт:**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 7555280.2 мянган төгрөгөөр нийт зарлагыг 755280.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Аймгийн төсвөөс үндсэн үйл ажиллагааны зардалд тусгай зориулалтын шилжүүлгээс 700452.1 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвөөс 31032.9 мянган төгрөгөөр нийт үйл ажиллагааны зардлыг 731485.0 мянган төгрөгөөр баталсан байна.

#### **Төсвийн гүйцэтгэл:**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 731485.0 мянган төгрөгийн төсөв баталснаас тусгай зориулалтын шилжүүлгээс 700452.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 31032.9 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 731485.0 мянган төгрөгийн төсөв баталснаас тусгай зориулалтын шилжүүлгээс 700452.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 31032.9 мянган төгрөгийн санхүүжилт авч 685701.7 мянган төгрөг зарцуулж 45833.2 мянган төгрөгийн төсвийн хэмнэлт гарган төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 685701.7 мянган төгрөг буюу 94% зарцуулсан байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийн 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн боловч хөтөлбөрөөс хэмнэлт гаргасан байна.

Хөтөлбөр арга хэмжээний хэмнэлтийг хүснэгтээр харуулбал:

Код	Хөтөлбөр, арга хэмжээ	Мөнгөн дүн
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	4,862.7
80109	Тогтмол зардал	13.3
81807	Хичээлийн үйлдвэрлэлийн зардал	27,234.1
81831	Бусдаар гүйцэтгүүлэх	6,214.5
81835	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	7,508.6
<b>ДҮН</b>		<b>45,833.2</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

#### **Нэмэлт санхүүжилт:**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт дансаар нийгмийн даатгалын сангаас 14917.6 мянган төгрөг, орон нутгийн хөгжлийн сангаас 4500.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Нэмэлт дансаар амаржсан эхийн лист 14917.6 мянган төгрөг, цэцэрлэгийн камержуулалд 2000,0 мянган төгрөг, цэцэрлэгийн гадна талбайд автомашины зогсоол хийхэд 2500.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

### **3.7. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 136 мэдээлэл оруулахаас хугацаандаа оруулсан 121, мэдээллийг огт оруулаагүй 6, мэдээлэл дутуу оруулсан 9 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүн бүхий орлого буюу сар бүрийн санхүүжилтийн мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулснаас зарлагын аудитын дүгнэлт, санхүүжилт, төвлөрүүлсэн санхүүжилтийн мэдээллийг байршуулаагүй байгааг нөхөн байршуулж залруулга хийсэн.

### 3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Булган сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах акт, зөвлөмжийг өгсөн байна. Хэрэгжилтийг хүснэгтээр харуулбал:

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	2,500.0	-	1,000.0	1	1,500.0	40
Албан шаардлага					-	-	-
Зөвлөмж	2	4,744.7	2	4,744.7	-	-	20
Нийт дүн	3	7,244.7	2	5,744.7	1	1,500.0	30

### 3.9. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 10454.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 3000.0 мянган төгрөгийн залруулсан алдаа, 7454.5 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчлөөс 377.4 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 7077.1 мянган төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж хүргүүлээ.

**Залруулсан алдаа:** Аудитаар тайлант хугацааны санхүүгийн тайлангаар мөнгөн хөрөнгийн тайланд 3000.0 мянган төгрөгийн орлого залруулсан.

#### **Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар төлбөрийн 377.4 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, албан шаардлага бичигдсэнгүй.

#### **1. Бараа материал**

1.1. **Илрүүлэлт:** Хувь хүнд нүүрсний үнэ олгоод хүн амын албан татвар суутгаагүй 377.4 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

1.2. **Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох**

**Аудитын зөвлөмж:** Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 7077.1 мянган төгрөгийн 4 алдаа, зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дараагийн аудитаар үр дүнгийн урамшууллын тушаал шийдвэрийн хэрэгжилт, хүнс, махны нөөцийн үлдэгдлийн зарцуулалтыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

#### **4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **2. Бараа материал**

2.1. **Илрүүлэлт:** Хүүхдийн хоолны зардлыг нормоос хэтрүүлэн зарцуулсан, хоолны талон засвар ихтэй, хүнсний тооллого хийгээгүй, амархан муудах ногоо, мах, сүүний үлдэгдэл ихтэй, их хэмжээгээр нөөцөлсөн, өмнөх оны зөвлөмж хэрэгжүүлээгүй 2865.7 мянган төгрөг зөрчил илэрлээ

- 2.2. Эрсдэл: Төсвийн хөрөнгийн үр өгөөж буурах, хуулийн хэрэгжилт хангагдахгүй, байх дотоод хяналтын үр дүнг хэрэгжүүлээгүй байх, хөрөнгийн ашиглалт хамгаалалт хангалтгүй байх
- 2.3. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.1.1-д "нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Төсвийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах" гэсэн заалтуудыг мөрдөн ажиллаж е-баримтын хэрэгжилтийг хангаж ажиллах,
- 2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

### **3. Хөрөнгө, материал**

- 3.1. Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн тооллого хийж үлдэгдлийг баталгаажуулаагүй, шинээр нэмэгдсэн хөрөнгө хүлээн авсан шийдвэргүй, бараа материалд хөрөнгө бүртгэлтэй хөрөнгө эмх цэгцгүй байгаа зөрчил илэрлээ.
- 3.2. Эрсдэл: Төсвийн хөрөнгийн үр өгөөж буурах, дотоод хяналт хэрэгжүүлээгүй байх, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал хангагдахгүй байх, хөрөнгийн ашиглалт буурах
- 3.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", Төсвийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх" Төсвийн тухай хуулийн 41-р зүйлийн 41.2.7-д "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах", 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.1.1-д "нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах" гэсэн хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах
- 3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

### **4. Түлш шатахуун**

- 4.1. Илрүүлэлт: Нүүрсний тооцоо хийж баталгаажуулаагүй, нормоос хэтрүүлэн нүүрс зарцуулж төсвийн үрэлгэн зардал гаргасан, анхан шатны баримтгүй гүйлгээ хийсэн, ашиг тооцож төсөвт төвлөрүүлээгүй, өмнөх оны зөрчил дахин давтан гарсан 2117.0 мянган төгрөг,
- 4.2. Илрүүлэлт: Өмнөх оны зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, шатахууны тооцоо хийгээгүй, тайлан хангалтгүй гаргасан, замын хуудсаар баталгаажуулаагүй, орлого, мөнгөн дүн зөрүүтэй, батлагдсан төсвөөс хэтэрсэн, анхан шатны баримтгүй гүйлгээ хийсэн 2094.4 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.
- 4.3. Эрсдэл: Төсвийн хөрөнгийн үр өгөөж буурах, хуулийн хэрэгжилт хангагдахгүй, байх дотоод хяналтын үр дүнг хэрэгжүүлээгүй байх, төсөв зориулалт бусаар зарцуулсан байх
- 4.4. Өгсөн зөвлөмж: Албан шаардлага бичих

Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 6 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

Огноо:	Аудитын нэр:	<b>Булган сумын Хүүхдийн 1-р цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	Аудитын код:
2021			ХОА-2021/145/СТА-
Шалгагдсан байгууллагын нэр:	<b>Булган сумын 1-р Цэцэрлэг</b>		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Хувь хүнд нүүрсний үнэ олгоод хүн амын албан татвар суутгаагүй	377.4	Төлбөрийн акт		
2	Нүүрсний тооцоо хийж баталгаажуулаагүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу гүйлгээ хийсэн, Шатахуун замын хуудсаар баталгаажуулаагүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу	4211.4	Зөвлөмж өгөх		
3	Үндсэн хөрөнгийн тооллого хийж үлдэгдлийг баталгаажуулаагүй, шинээр нэмэгдсэн хөрөнгө хүлээн авсан шийдвэргүй, бараа материалд хөрөнгө бүртгэлтэй байна	0	Зөвлөмж		
4	Хүүхдийн хоолны талон засвар ихтэй, хүнсний тооллого хийгээгүй, амархан муудах ногоо, мах, сүүний үлдэгдэл ихтэй, их хэмжээгээр нөөцөлсөн	2865.7	Зөвлөмж		
5	Мөнгөн хөрөнгийн тайланд орлого дутуу тайлагнасан, зардал хооронд гүйлгэн зарцуулсан нь төрийн сангийн журам баримтлаагүй	3000.0	Залруулга хийх		
<b>ДҮН</b>		<b>10454.5</b>			

### ХОВД АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР